



Хэвлэлийн мэдэгдэл No. 18/261
ДАРУЙ МЭДЭГДЭХ
2018 оны 6-р сарын 27

Олон Улсын Валютын Сан
Вашингтон, Ди.Си. 20431 АНУ

ОУВС Гүйцэтгэх зөвлөл Монгол Улсад хэрэгжүүлж буй Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд дөрөвдэх удаагаа үнэлгээ дүгнэлт өгч, 36.91 сая ам.долларын зарцуулалтыг баталлаа

- Хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн эхний нэг жилийн хугацаанд Монгол Улсын эдийн засгийн гүйцэтгэл төсвийн болон нөөцийн чухал зорилтуудыг давуулан биелүүлж, хүчтэй хэвээр үргэлжилж байна.
- Төсвийн бодлого, банкны салбарыг бэхжүүлэхэд чиглэгдсэн бүтцийн шинэчлэлүүд хийгдэж эхэлсэн ч хэрэгжилтэд зарим нэг саатал үүсчээ.
- Улсын өрийн хэмжээ өндөр, эдийн засаг дэлхийн бараа бүтээгдэхүүний хөгжилд өртөж байгаа энэ цаг үед эрх баригчид уг хөтөлбөрт тууштай хандах нь чухал хэвээр байна.

2018 оны 6-р сарын 27-ны өдөр Олон Улсын Валютын Сангийн (ОУВС) Гүйцэтгэх зөвлөл Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн (ӨСХ) дор гурван жилийн өргөтгөсөн санхүүжилтээр дэмжигдэж буй хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын гүйцэтгэлд дөрөвдэх удаагаа үнэлгээ дүгнэлт хийлээ. Ийнхүү үнэлгээ дүгнэлтийг хийж дууссанаар Монгол Улс 26.2088 саяын зээлжих тусгай эрхтэй (36.91 сая ам. доллар орчим) тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг татах боломжтой болж байгаа юм. Ингэснээр зохицуулалтын дор зарцуулагдсан нийт хэмжээ 131.0366 саяын зээлжих тусгай эрх (184.55 сая ам.доллар орчим) болж байна.

Хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын гүйцэтгэл хүчтэй хэвээр байна. Хүчтэй бодлого хэрэгжүүлж, гадаад орчноос дэмжлэг авсан нь эрх баригчдад хөтөлбөрийн 2018 оны 3 дугаар сарын эцэс гэхэд биелүүлэхээр зорьж байсан бүх тоон зорилтыг давах биелүүлэхэд нь тус нэмэр болжээ. Мөн түүнчлэн зарим нэг саатлыг үл тооцон бүтцийн шинэчлэл хийх тал дээр ахиц гарсан байна.

Монгол Улсын гурван жилийн өргөтгөсөн санхүүжилтийн зохицуулалт нь хөтөлбөр батлагдах үед ([Хэвлэлийн мэдэгдэл No. 17/193](#)-г үзнэ үү) буюу 2017 оны 5 дугаар сарын 24-ны өдөр 314.5054 саяын зээлжих тусгай эрх буюу 434.3 сая ам.долларын хэмжээгээр батлагдсан билээ. ОУВС-аас дэмжлэг үзүүлж буй Засгийн газрын “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийн зорилго нь эдийн засгийг тогтворжуулж, төсвийн алдагдал болон өрийг бууруулж, гадаад валютын нөөцийг дахин бий болгох, өсөлт-

уналтын мөчлөгийг багасгаж, тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хөхүүлэн дэмжихэд чиглэгдсэн арга хэмжээг нэвтрүүлэхэд оршиж байна.

Гүйцэтгэх зөвлөл үнэлгээ дүгнэлтийг хэлэлцсэний дараа Тэргүүлэгчийн үүрэг гүйцэтгэгч ба Орлогч ерөнхий захирал ноён Тао Жан:

“Монгол Улс Сангийн дэмжлэгтэй хөтөлбөрийн хүрээнд маш сайн ахиц гаргаж байна. Таатай гадаад орчин бүрдүүлж, хөтөлбөрийг хүчтэй хэрэгжүүлсний үр дүнд өсөлт хүчээ авч, төсвийн тогтвортой байдал, өрийн динамик, гадаад бамбайнууд (буфер) ихээхэн сайжирсан байна.

“Хөтөлбөрийн хүрээнд 2018 оны 3 дугаар сарын эцэс гэхэд биелүүлэхээр зорьж байсан бүх тоон зорилтоо давуулан биелүүлжээ. Төсвийн дансууд анхдагч илүүдэл заасан нь тогтвортой гүйцэтгэлийг харуулж байна. Энэ нь үндсэндээ орлого огцом өссөний тусгал юм. Энэ хооронд олон улсын нөөцүүд хөтөлбөр эхэлснээс хойшхи хугацаанд даруй хоёр дахин нэмэгджээ.”

“Санхүүгийн салбарыг бэхжүүлэх шинэчлэлүүд хийгдэж байна. 1 дүгээр сард хөрөнгийн чанарт өгсөн үнэлгээ дүгнэлтэд заасны дагуу арга хэмжээ авах тал дээр төвлөрөн ажиллаж байна. Тодорхойлж гаргасан хомсдлуудыг шийдвэрлэхийн тулд банкууд хөрөнгө мөнгө босгох ажлыг хийж байна. Нэмж хэлэхэд банкны салбарын тогтвортой байдлыг хадгалж үлдэх үүднээс эрх баригчид улсын хөрөнгийг хэзээ ба хэрхэн ашиглаж болохыг тусгасан хууль гаргажээ.”

“Энэхүү ахицаас үл хамааран Монгол Улс гадаад болон дотоод цочролуудад өртөмтгий хэвээр байна. Тиймээс одоогийн эдийн засгийн таатай орчны давуу талыг ашиглан төсвийн болон гадаад солилцооны бамбайнуудыг (буферууд) үргэлжлүүлэн барьж, банкны салбарыг бэхжүүлж, хөрөнгө оруулалтын уур амьсгалыг сайжруулах нь нэн чухал байна. Эрх баригчдын шинэчлэлийн хөтөлбөрийг тууштай, эрчимтэй хэрэгжүүлэх нь цочролд тэсвэртэй болж, хүчтэй бөгөөд хүртээмжтэй өсөлтийг үргэлжлүүлэн хангах явдлын гол түлхүүр байх болно” гэж хэлжээ.